



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 5/35

Чингис хот

Д.Баасандоржийг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 23 дугаар зүйлийн 23.2.3, 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.5, 46.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Эрүүл мэндийн газрын Эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Баасандоржийг АТГ-ын 2020 оны 05/6029 тоот албан бичгийг үндэслэн 2020 оны 08 дугаар сарын 10-ны эдрөөс эхлэн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулсугай.

2. Д.Баасандоржийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Лхагвахатан Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Т.Байгалсүрэн Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн мэргэжилтэн

М.Дагва Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч

Т.Ууганжаргал Эрүүл мэндийн газрын нярав

Нарийн бичгийн дарга: Ж.Цэнджав Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

3. Д.Баасандоржид орлон гүйцэтгэсэн хугацааны албан тушаалын цалингийн зөрүүг тооцон олгохыг Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч /М.Дагва/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010351